



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 7 дугаар цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2022/191-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2022 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: enkhuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитор: А.Гэрэлмаа Утас: 99499667 Цахим хаяг: infoauditselenge@gmail.com
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	11
3.Аудитын тайлан	13
3.1. Ерөнхий зүйл.....	14
3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	15
3.4. Материаллаг байдал	15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	15
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	17
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	18
3.8 Аудитын гол асуудал	18
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асудитын асуудал	18
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19
4. Аудитын илрүүлэлт.....	20
4.1 Залруулсан алдаа	Error! Bookmark not defined.
4.2 Төлбөрийн акт	Error! Bookmark not defined.
4.3 Албан шаардлага	Error! Bookmark not defined.
4.3 Зөвлөмж.....	20
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
СЭА	Сэлэнгэ аймаг
ТШЗ	Төсвийн шууд захирагч
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
АНУ	Америкийн нэгдсэн улс
ИТХТ	Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчид
МУЕА	Монгол улсын ерөнхий аудитор



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.02.25 № СЭА-2022/191-НА-СТА-ТШЗ

танай _____-ны № _____-г

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 7 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 7 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	37,294,824.57	33,077,315.23
35	БАРАА МАТЕРИАЛ	37,294,824.57	33,077,315.23
35400	Хангамжийн материал	37,294,824.57	33,077,315.23
35420	Аж ахуйн материал	36,974,964.57	32,893,392.23
35460	Хүнсний материал	217,494.00	76,557.00
35470	Бусад хангамжийн материал	102,366.00	107,366.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	785,332,303.48	2,452,976,408.42
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	785,332,303.48	2,452,976,408.42
39200	Биет хөрөнгө	742,816,303.48	2,410,210,408.42
39201	Барилга, байгууламж, орон сууц	669,387,292.04	1,942,395,092.04
39202	Хуримтлагдсан элэгдэл	(13,976,786.92)	(35,593,001.48)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	72,680,851.72	62,764,831.72
39206	Хуримтлагдсан элэгдэл	(40,795,078.97)	(8,358,380.25)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	26,373,557.54	23,747,357.54
39208	Хуримтлагдсан элэгдэл	(9,973,538.05)	(9,618,224.81)
39214	Бусад үндсэн хөрөнгө	59,722,117.05	465,237,660.99
39215	Хуримтлагдсан элэгдэл	(22,767,471.93)	(32,530,288.33)
39217	Ном	2,165,361.00	2,165,361.00
39300	Биет бус хөрөнгө	42,516,000.00	42,766,000.00
39301	Програм хангамж	250,000.00	250,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(250,000.00)	-
39303	Бусад биет бус хөрөнгө	42,516,000.00	42,516,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	822,627,128.05	2,486,053,723.65
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	822,627,128.05	2,486,053,723.65
51	Засгийн газрын хувь оролцоо	822,627,128.05	2,486,053,723.65
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	430,890,181.10	430,890,181.10
51200	Хуримтлагдсан үр дүн	311,455,304.42	1,974,898,667.02
51210	Өмнөх үеийн үр дүн	3,411,772.86	311,472,071.42
51220	Тайлант үеийн үр дүн	308,043,531.56	1,663,426,595.60
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	80,281,642.53	80,264,875.53
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	822,627,128.05	2,486,053,723.65

2.2 Аудит хийсэн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	732,849,718.00	2,126,030,065.55
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	317,959,333.00	1,715,250,444.92
120	Нийтлэг татварын бус орлого	317,959,333.00	1,715,250,444.92
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	315,859,643.00	1,713,074,340.66
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	2,099,690.00	2,176,104.26
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	414,890,385.00	410,779,620.63
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	385,038,500.00	372,995,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	385,038,500.00	372,995,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	136,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	136,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	29,851,885.00	37,647,720.63
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	29,851,885.00	37,647,720.63
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	424,806,186.44	460,445,408.71
21	УРСГАЛ ЗАРДАЛ	424,806,186.44	460,445,408.71
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	380,656,598.21	442,972,956.92
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	268,632,659.15	292,492,248.42
210101	Үндсэн цалин	203,850,534.50	206,933,071.82
210102	Нэмэгдэл	42,048,182.65	65,343,405.70
210104	Урамшуулал	18,566,015.00	20,215,770.90
210105	Гэрээт ажлын хөлс	4,167,927.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,293,102.62	37,744,425.79
210201	Тэтгэврийн даатгал	23,871,455.54	26,547,905.60
210202	Тэтгэмжийн даатгал	2,739,100.27	2,954,611.77
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,010,686.56	2,340,169.44
210204	Ажилгүйдлийн даатгал	498,103.39	520,456.19
210205	Эрүүл мэндийн даатгал	5,173,756.86	5,381,282.79
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,201,885.00	37,647,720.63
210301	Гэрэл, цахилгаан	22,851,885.00	35,897,720.63
210302	Түлш, халаалт	7,350,000.00	-
210303	Цэвэр, бохир ус	-	1,750,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,717,580.00	14,192,066.60
210401	Бичиг хэрэг	505,000.00	556,450.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	77,530.00	465,790.00
210404	Ном, хэвлэл	45,000.00	45,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,480,000.00	1,087,750.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,610,050.00	1,638,532.00

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 7 дугаар цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210408	Бараа материал акталсны зардал	-	10,398,544.60
2105	Нормативт зардал	14,433,860.00	9,069,971.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	270,000.00	200,000.00
210502	Хоол, хүнс	14,163,860.00	8,759,971.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	110,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,000,000.00	1,500,000.00
210604	Урсгал засвар	5,000,000.00	1,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	-	79,000.00
210702	Дотоод албан томилолт	-	79,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,701,400.00	658,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	127,400.00	10,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	648,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,250,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	21,676,111.44	49,589,524.48
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	374,000.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,601,200.00	1,127,550.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	19,700,911.44	48,461,974.48
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	44,149,588.23	17,472,451.79
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	300,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	300,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	44,149,588.23	17,172,451.79
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	44,149,588.23	17,172,451.79
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	308,043,531.56	1,665,584,656.84
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	2,158,061.24
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	-	2,158,061.24
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	308,043,531.56	1,663,426,595.60
VI-I	Засгийн газрын хувь оролцоо	-	-
VI-II	Хяналтын бус хувь оролцоо	-	-

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	414,890,385.00	410,779,620.63
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	414,890,385.00	410,779,620.63
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	385,038,500.00	372,995,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	385,038,500.00	372,995,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	136,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	136,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	29,851,885.00	37,647,720.63
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	29,851,885.00	37,647,720.63
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	409,340,385.00	405,589,820.63
21	УРСГАЛ ЗАРДАЛ	409,340,385.00	405,589,820.63
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	365,190,796.77	388,117,368.84
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	268,632,659.15	292,492,248.42
210101	Үндсэн цалин	192,535,697.40	192,230,148.48
210102	Нэмэгдэл	53,165,403.75	80,046,329.04
210104	Урамшуулал	18,763,631.00	20,215,770.90
210105	Гэрээт ажлын хөлс	4,167,927.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,293,102.62	37,744,425.79
210201	Тэтгэврийн даатгал	23,671,201.54	26,547,905.60
210202	Тэтгэмжийн даатгал	2,785,870.27	2,954,611.77
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,031,619.56	2,340,169.44
210204	Ажилгүйдлийн даатгал	630,654.39	520,456.19
210205	Эрүүл мэндийн даатгал	5,173,756.86	5,381,282.79
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,851,885.00	37,647,720.63
210301	Гэрэл, цахилгаан	22,851,885.00	35,897,720.63
210302	Түлш, халаалт	7,000,000.00	-
210303	Цэвэр, бохир ус	-	1,750,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,585,840.00	4,148,940.00
210401	Бичиг хэрэг	520,000.00	712,950.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	77,530.00	465,790.00
210404	Ном, хэвлэл	45,000.00	45,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,480,000.00	1,225,750.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,463,310.00	1,699,450.00
2105	Нормативт зардал	16,140,910.00	13,179,034.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	240,000.00	200,000.00
210502	Хоол, хүнс	12,900,910.00	8,619,034.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,000,000.00	4,360,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,000,000.00	1,500,000.00
210604	Урсгал засвар	5,000,000.00	1,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	-	79,000.00

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 7 дугаар цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210702	Дотоод албан томилолт	-	79,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,797,400.00	658,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	223,400.00	10,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	648,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,250,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	889,000.00	668,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	389,000.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	500,000.00	668,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	44,149,588.23	17,472,451.79
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	300,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	300,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	44,149,588.23	17,172,451.79
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	44,149,588.23	17,172,451.79
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	5,550,000.00	5,189,800.00
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	-	-
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	5,550,000.00	5,189,800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,550,000.00	5,189,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	5,550,000.00	5,189,800.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	5,550,000.00	5,189,800.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(5,550,000.00)	(5,189,800.00)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-	-
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	430,890,181.10	80,281,642.53	3,411,772.86	514,583,596.49
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	430,890,181.10	80,281,642.53	3,411,772.86	514,583,596.49
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
7	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
8	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
9	Тайлант үеийн үр дүн	-	-	308,043,531.56	308,043,531.56
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	430,890,181.10	80,281,642.53	311,455,304.42	822,627,128.05
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	430,890,181.10	80,281,642.53	311,455,304.42	822,627,128.05
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	16,767.00	16,767.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	430,890,181.10	80,281,642.53	311,472,071.42	822,643,895.05
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	(16,767.00)	-	(16,767.00)
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
17	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
18	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
19	Тайлант үеийн үр дүн	-	-	1,663,426,595.60	1,663,426,595.60
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	430,890,181.10	80,264,875.53	1,974,898,667.02	2,486,053,723.65

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	441,713,300.00	393,471,168.84
21	УРСГАЛ ЗАРДАЛ	441,713,300.00	393,471,168.84
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	441,413,300.00	393,171,168.84
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	296,525,100.00	292,492,248.42
210101	Үндсэн цалин	213,749,300.00	192,230,148.48
210102	Нэмэгдэл	62,546,100.00	80,046,329.04
210104	Урамшуулал	20,229,700.00	20,215,770.90
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,607,000.00	37,744,425.79
210201	Тэтгэврийн даатгал	27,169,000.00	26,547,905.60
210202	Тэтгэмжийн даатгал	2,567,300.00	2,954,611.77
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,347,200.00	2,340,169.44
210204	Ажилгүйдлийн даатгал	593,100.00	520,456.19
210205	Эрүүл мэндийн даатгал	5,930,400.00	5,381,282.79
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	68,717,400.00	37,647,720.63
210301	Гэрэл, цахилгаан	64,667,400.00	35,897,720.63
210303	Цэвэр, бохир ус	4,050,000.00	1,750,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,238,400.00	4,012,940.00
210401	Бичиг хэрэг	714,400.00	712,950.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	620,000.00	465,790.00
210404	Ном, хэвлэл	74,000.00	45,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,130,000.00	1,089,750.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,700,000.00	1,699,450.00
2105	Нормативт зардал	27,133,400.00	16,419,034.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	200,000.00	200,000.00
210502	Хоол, хүнс	19,333,400.00	8,619,034.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,600,000.00	7,600,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,500,000.00	3,449,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,000,000.00	1,949,800.00
210604	Урсгал засвар	1,500,000.00	1,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	120,000.00	79,000.00
210702	Дотоод албан томилолт	120,000.00	79,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,272,000.00	658,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	300,000.00	10,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	972,000.00	648,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,300,000.00	668,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,300,000.00	668,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	300,000.00	300,000.00

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 7 дугаар цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2132	Бусад урсгал шилжүүлэг	300,000.00	300,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00	300,000.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	441,713,300.00	393,471,168.84
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	372,995,900.00	355,823,448.21
310001	Улсын төсвөөс санхүүжих	-	-
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	372,995,900.00	355,823,448.21
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	68,717,400.00	37,647,720.63
320001	Орон нутгийн төсвөөс	68,717,400.00	37,647,720.63
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	216	216
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	32	32
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	9	9
620003	Үйлчлэх ажилтан	22	22
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	151	151
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	151	151
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	151	151
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	32	32
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	32	32

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		136,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		136,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		136,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал		136,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		136,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		136,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		136,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		136,000.00

3. АУДИТЫН ТАЙЛАН

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 7 дугаар цэцэрлэгийн /цаашид Сүхбаатар сумын 7 дугаар цэцэрлэг гэх/ 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд өгсөн төлбөрийн цахим баримттай холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу Мэдээлэл аудит ХХК-ийн Сэлэнгэ салбарын аудитор А.Гэрэлмаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар сумын 7 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Мэдээлэл аудит ХХК-ийн Сэлэнгэ салбарт 2022 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Сүхбаатар сумын 7 дугаар цэцэрлэг нь *"Хичээл, сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах, хүүхдийн хөгжлийн хоцрогдлыг арилгахад бүх талын хамтын ажиллагааг сайжруулж ажиллая"* гэсэн зорилт тавин ажиллаж байна.

Сүхбаатар сумын 7 дугаар цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

- Сургуулийн өмнөх насны хүүхдэд боловсрол олгох

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар шинэчлэгдсэн,
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах босго үнийг “Босго үнэ шинэчлэн батлах тухай” Монгол улсын засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор шинэчлэн хийгдсэн гэх мэт

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж дүгнэж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас Сүхбаатар сумын 7 дугаар цэцэрлэгийн 2019, 2020 оны санхүүгийн үйл ажиллагаа, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийж санхүүгийн үйл ажиллагааг үнэн зөв илэрхийлэн зориулалтын дагуу зарцуулсан, бүртгэл хөтлөлт, шилэн дансны мэдээлэл байршуулалт хангалттай сайн гэж үнэлэгдсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар сумын 7 дугаар цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4. Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлэн, материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 424,806.2 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 4,248.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувь буюу 2,973.6 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Сүхбаатар сумын 7 дугаар цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,663,426.6 мянган төгрөгөөр буюу 202.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс авлага, бараа материал,

үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын оролцоо дансдад материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1: Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Ажиллагчидтай холбогдсон авлага			
Татаас санхүүжилтийн авлага			
Байгууллагаас авах авлага			
Урьдчилж төлсөн зардал			
Бараа материал	37,294.8	33,077.3	(4,217.5)
Үндсэн хөрөнгө	785,332.3	2,452,976.4	1,667,644.1
Нийт хөрөнгө	822,627.1	2,486,053.7	1,663,426.6
Өр төлбөр			-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	822,627.1	2,486,053.7	1,663,426.6
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	822,627.1	2,486,053.7	1,663,426.6

Бараа материалын дансны үлдэгдэл 4,217.5 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн хүнсний материал, аж ахуйн материал, хангамжийн материалын зарцуулалтаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 1,665,981.1 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр нийт 5,189.8 мянган төгрөгийн хөлдөөгч, ус шүүгч, дрож, махны машин зэргийг худалдан авсан болон БШУЯ-аас 100,544.6 мянган төгрөгийн дизель генератор, АНУ-ын элчин сайдын яамны хөрөнгө оруулалтаар 1,273,007.8 мянган төгрөгийн барилга, 306,055.2 мянган төгрөгийн цахилгаан болон дулааны узель, төмөр хашаа, гүний худаг, бохирын танк зэрэг нийт 1,579,063.0 мянган төгрөгийн 50 хүүхдийн иж бүрэн цэцэрлэгийн барилгыг үнэ төлбөргүйгээр хүлээн авч авч Орон нутгийн өмчийн газрын 2021 оны 607 тоот зөвшөөрлийн бичгийг үндэслэн данс бүртгэлд тусгаснаас шалтгаалсан байна. Мөн Сүхбаатар сумын ИТХТ-ийн 2021 оны 40 тогтоолоор 17,816.3 мянган төгрөгийн тавилга, тоног төхөөрөмжийг акталж данс бүртгэлээс хасагдуулсан байна.

Орон нутгийн өмчийн газрын 2021 оны 503 тоот зөвшөөрлийн бичгийг үндэслэн 33,466.7 мянган төгрөгийн анхны үнэ бүхий “0” үлдэгдэлтэй хөрөнгийн ашиглах хугацааг шинээр тогтоосон байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 2,486,053.7 мянган төгрөг болж 1,663.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого 2,126,030.1 мянган төгрөг болж өмнөх оноос 1,393,2180.3 мянган төгрөгөөр буюу 190.1 хувиар өссөн байна. Энэ нь АНУ-ын элчин сайдын яамны хөрөнгө оруулалтаар баригдсан 50 хүүхдийн цэцэрлэгийн иж бүрэн барилгыг хүлээн авч, үнэ төлбөргүй орлогоор тайлагнаснаас шалтгаалсан байна.

Тайлант оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 460,445.4 мянган төгрөг болж өмнөх оноос 35,639.2 мянган төгрөгөөр буюу 8.4 хувиар өссөн. Энэ нь шинэ цэцэрлэг ашиглалтад орсонтой холбоотой цахилгаан, элэгдлийн зардал өссөн нь голлон нөлөөлсөн байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Сүхбаатар сумын 7 дугаар цэцэрлэг нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг тус бүр 522,129.1 мянган төгрөгөөр тооцон төсөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг 80,415.8 мянган төгрөгөөр бууруулан 441,713.3 мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр **441,713.3** мянган төгрөгийн төсөв баталснаас 372,995.9 мянган төгрөгийг улсын төсвөөс /тусгай зориулалтын шилжүүлгээр/, 68,717.4 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 372,995.9 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 37,647.7 мянган төгрөгийн санхүүжилт нийт 410,643.6 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 393,471.2 мянган төгрөгийг зарцуулан, 17,172.5 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **393,471.2** мянган төгрөг буюу 89.1 хувьтай тайлагнагдсан нь Ковид-19 цар тахалтай холбоотойгоор хичээлийн жилд бүрэн хичээллээгүйгээс тогтмол зардал 31,069.7 мянган төгрөгөөр, цалингийн зардал 4,032.8 мянган төгрөгөөр, НДШ-ийн зардал 862.6 мянган төгрөгөөр, хоол 10,714.3 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардал 225.5 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардал 50.2 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 632.0 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал 655.0 мянган төгрөг зэрэг нийт 48,242.2 мянган төгрөгийн зардлыг хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд Боловсрол соёл урлагийн газраас /Ковид-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх ариутгалын ажилд

дэмжлэг үзүүлж 136.0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосныг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

3.7.1 Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журмын 3 дахь *“Төрийн үйлчилгээний байгууллагын удирдах, гүйцэтгэх, туслах албан хаагчид төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлж байх хугацаанд нь ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг энэ журмын 4-т заасан шалгуур үзүүлэлтийн дагуу албан тушаалын сарын үндсэн цалингаас 10-25 хувиар тооцож, сар бүр олгоно.”* гэсэн заалт болон Боловсрол шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны А/35,А/10/9 тушаалын 10 дахь *“цэцэрлэг, сургуулийн түвшинд амжилт гаргасан 10%, сум, дүүргийн түвшинд амжилт гаргасан 15%, аймаг, нийслэлийн түвшинд амжилт гаргасан 20%, улс, бүс, олон улсын түвшинд амжилт гаргасан 25%”* гэж заасан боловч цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч, багш, туслах багшийн ажлын үр дүнг нь шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж, дүгнэлгүйгээр ур чадварын нэмэгдлийг сард 10-25 хувиар тооцож олгож байна. Цаашид ажлын үр дүнг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж дүгнэн олгож байх нь зүйтэй юм.

3.7.2 БШУ-ны сайд болон Эрүүл мэндийн сайдын 2021 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн А/292, А/525 дугаар хамтарсан “Түр журам журам батлах тухай” тушаалын нэгдүгээр хавсралт “Короновируст халдварын үед цэцэрлэгийн сургалт, үйл ажиллагааг зохион байгуулахад мөрдөх түр журам”-ын дагуу сургалтын үйл ажиллагааг танхим болон танхимын бус сургалтад шилжүүлсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансанд нийт мэдээлбэл зохих 149 мэдээллээс 146 мэдээллийг хугацаанд нь, 1 мэдээллийг хугацаа хоцроож, 2 мэдээллийг огт мэдээлээгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.9.2 Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Сүхбаатар сумын 7 дугаар цэцэрлэгийн тайлант оны үйл ажиллагаанд **441,713.3** мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр **393,471.2** мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 10.9 хувиар хэмнэсэн нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д: “.....*батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах*” гэж заасныг бүрэн хэрэгжүүлсэн байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 875.4 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 төлбөрийн акт, шилэн данстай холбоотой 1 зөвлөмжийг хүргүүлснээс шилэн данстай холбоотой 1 зөвлөмжийг биелүүлээгүй байна.

Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Төлбөрийн акт	1	875.4	1	875.4	100
Зөвлөмж	1	-	-	-	-
Нийт дүн	2	875.4	1	875.4	50

Өмнөх аудитаар өгсөн холбогдох мэдээллийг шилэн дансны цахим хуудаст тогтоосон хугацаанд мэдээлж байх зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

3.11.1 Аудитын цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан 1,718,264.1 мянган төгрөгийн шинээр нэмэгдэж, бүртгэгдсэн хөрөнгүүдийг биетээр тулган баталгаажуулах боломжгүй байсан учир дараагийн аудитаар анхааран үзэх нь зүйтэй юм.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 29,304.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрч 1 зөвлөмж өглөө.

4.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.

1.Бараа, ажил, үйлчилгээний төлбөр тооцооны баримтууд

1.1 Илрүүлэлт: Тайлант онд 29,304.1 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5-д “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэсэн заалт болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэж заасны дагуу төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг гүйцэтгэж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Сүхбаатар сумын 7 дугаар цэцэрлэг	1	29,304.1	-	-			-	-	1	29,304.1